

Ж.Бор

Гурван хэмжээст Монгол
сэтгэхүйг геостратегийн
бодлогод ашиглахуй

Б.Баяржаргал

БНХАУ-ЫН Зүүн Хойд Азид
явуулж буй бодлого ба
Монгол Улс

З.Болор

"Covid-19" цар тахал ба
вакцины дипломат ажиллагаа

БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2021.09 №19



Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС

02 Гурван хэмжээст Монгол сэтгэхүйг геостратегийн бодлогодоо ашиглахуй

05 БНХАУ-ЫН Зүүн хойд Азид явуулж буй бодлого ба Монгол улс

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

08 “Covid-19” цар тахал ба вакцины дипломат ажиллагаа

Тоон мэдээ

Хуанли

Сэтгүүлийг эрхлэн хэвлүүлсэн: С.Баттулга

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн: Х.Бэхбат

Эх бэлтгэгч: О.Отгонжаргал

Хэвлэсэн газар: “Удам Соёл” ХХК

“Бодлогын мэдээ” сэтгүүлийг МУИС-ийн ОУХНУС бодлогын судалгааг дэмжих зорилгоор санхүүжүүлж эрхлэн гаргав.

Зун цаг.

Зуны дэлгэр зургадугаар сар хур бороогоор арвины зэрэгцээ улс орны хувь заяаг цаашид тээх үйл явдлаар баян байлаа.

Төрийн тэргүүнээ сольж сонгох ажил өрнөж, эртнээс зэхэн, зам нь ч шулуудаад байсан У.Хүрэлсүх өндөр суудалдаа залрав. Сонгуулийн өмнөхөн МАХНам МАН-д нэгдэж, АН задралаа бататгаснаар төр, нийгмийн жолоо улс төрийн нэг хүчний гарт төвлөрөв. Гүйцэтгэх засгийн тэргүүн намынхаа дарга болсоноор нэг талаас “үг, үйлс” хоёрын нэгдлийн үндэс бэхжихийн зэрэгцээ нөгөө талаас “нам төвтэй төрийн” тогтолцоо улам лавширав гэлтэй.

“Ковид”-ийн үер нэгэнтаа бууж эдүгээ татрах аядаж атал усны үер наадамтай хавсран буух вий гэх бас нэг айдас томорсоор...

Мэргэн уншигч Танаа гэр орондоо сайхан наадаж, өөдөө тэмүүлж, эрүүл энх явахын ерөөл дэвшүүлье !

* * *

“The first duty of a man is to think for himself”

Jose Marti

“Supreme excellence consists of breaking the enemy's resistance without fighting.”

Sun Tzu, The Art of War

“The greatest and most powerful revolutions often start very quietly, hidden in the shadows. Remember that.”

Richelle Mead, Vampire Academy

“People are always shouting they want to create a better future. It's not true. The future is an apathetic void of no interest to anyone. The past is full of life, eager to irritate us, provoke and insult us, tempt us to destroy or repaint it. The only reason people want to be masters of the future is to change the past.”

Milan Kundera



Ж.Бор

Доктор, профессор

ГУРВАН ХЭМЖЭЭСТ МОНГОЛ СЭТГЭХҮЙГ ГЕОСТРАТЕГИЙН БОДЛОГОДОО АШИГЛАХУЙ¹

Монгол орны геополитикийн өвөрмөц байдлыг хараад гадаадын Монгол судлаач-эрдэмтэд хоёр зүйлээр нэн гайхдаг. Тухайлбал *нэгд*, Монголчууд төр улсаа байгуулж оршин тогтносон гурван мянга хоёр зуун жилийн туршид хүн ам нь таван зуун мянгаас долоон зуун мянгахан байсан мөртлөө гурван удаа дэлхийн хэмжээний хэт их гүрэн байгуулсан, ХХ зуунд бүх талаараа олон зуун сая хүн амтай хоёр их гүрнээр бүслэгдсэн атлаа тусгаар тогтнолоо хадгалан үлдэж хэрхэн чадсан байна вэ? *Хоёрт*, хөрш их гүрнүүдийнхээ асар хүчтэй шахалт, нөлөөн дор байсан атлаа тусгаар тогтнолоо хадгалан үлдсэн төдийгүй хүн амын нь тоотой харьцуулбал асар том нутаг дэвсгэрийг тусгаар тогтнол дороо авч үлдэж хэрхэн чадсан юм бэ?

Эдгээр асуудал зөвхөн харийн эрдэмтдийн ч бус дэлхийн олон хүмүүсийн бодол санааг гайхшруулсаар,

сэтгэл зүрхийг нь эзэмдэн санаашруулсаар байгаа билээ. Тэгэхлээр байж болшгүй гэж тооцогдсон энэ явдал чухамдаа ямар юмнаас урган гарсан байх нь вэ. Монголчуудын аварга их тэмцлийн үр дагавар уу? Аль алиндаа өгөхгүй хэмээн булаацалдаж байсан хоёр их гүрний тэмцлийн хий зөрөөний үр дагавар уу? Аль эсвэл Монголчуудын арга ухааны үр дүн үү?

Үүнийг яаж ч тайлбарлаж болох боловч энэ гурван хүчин зүйл нь өвөр хоорондоо салшгүй, холбоотой билээ. Тиймээс аль нэгий нь онцгойлон авч үзсэн тэр тайлбарт нөгөө хоёр нь заавал ч үгүй зохих байр сууриа эзлэн наалдаж орж ирэхээс өөр замгүй болдог. Эл учраас миний ойлгож буйгаар Монголчууд бид тусгаар тогтнолынхоо ирээдүйн хувь заяанд санаа зовинох бүрийдээ Монголын эргэн тойронд хийгээд дэлхий дахинд шинэ нөхцөл байдал

бүрэлдэн тогтож жижиг улсын тусгаар тогтнолын асуудал шиг эмзэг асуудал илэгдэх бүрийд Монгол хүн бүрд эрхэмээс эрхэм тусгаар тогтнолын асуудлаа ямар аргаар бэхжүүлэх вэ? гэдэг арга ухаан сийлж, түүхээ нэгжин уудалж эрэл хайгуулд гарах, басхүү бүрэлдэн тогтсон нөхцөл байдлыг задлан шинжилж, бидэнд ашигтайгаар тус болж болох хүчний эрэлд гардаг байж магад билээ. Эх нутгийнх нь тусгаар тогтнолын асуудал Монголчуудын оюун бодлыг цаг ямагт зовоож явдаг ч гэж хэлж болно.

Тэгэхлээр өнөөдөр Монголын тусгаар тогтнолын асуудал ямархуу байна вэ? Үүнийг хэрхэн байнга бөгөөд тогтвортойгоор бэхжүүлж байх вэ? Тийм арга бий болов уу. Тэр тусмаа тусгаар тогтнолоо улс төр-дипломатын аргаар бэхжүүлнэ гэж тунхагласан үед тийм арга бий болов уу. Урьд үеийнхээ арга ухааныг

¹ Гурван хэмжээст ертөнцөд гурван цагийг нийлүүлж сэтгэх чухал. Монголчууд суурин иргэншлийнхээ нэг хэмжээсээр илүү гарч сэтгэдэг учраас аливааг товч тодорхой томъёолж боловсруулан гаргах өндөр чадвартай байдаг. Тэр ер бусын чадварыг суурин иргэншлийнхэнээ сондгойрч гарч ирсэн Гегель мэтийн эрдэмтэн мэргэд нь «Монголчууд бол хүн төрлөхтөнд оюун ухаан хайрласан ард түмэн» хэмээн үнэлж биширсэн байдаг. Үнэхээр ч Монголчуудын гүн ухааны гурвал томъёолол буюу «ертөнцийн гурав»-т нэвтэрхий харц, эрдэм мэдлэгийн их багцлал нэвт шингэсэн байдаг.

эрэлхийлэн үүх түүхээ нэгжвэл арга чарга төдийгүй пууц арга ч олдож болох юм.

Энэ аргыг Монголчуудын ажахуйгаа эрхэлж, орчин ахуйдаа мянга мянган жилийн өмнө боловсруулсан арга ухаанаас олж болох мэт ээ. Тухайлбал Монголчуудын нүүдлийн мал аж ахуй дахь нэгэн аргачлал өнөөгийн бидний тунхагласан “*тусгаар тогтнолоо улс төр-дипломатын аргаар хамгаалах*” аргачлалын үүднээс харахад зүй ёсоор анхаарал татаж байна.

Монголчуудын гэрийн тэжээмэл амьтан гэж нэрлэдэг таван хошуу малын зан араншинг нягтлан ажиглах юм бол нэгэн өвөрмөц сонин байдал буйг эрхбиш олж харж болно. Монгол мал гэрийн тэжээмэл амьтан мөн боловч суурин иргэдийн мал шиг байшинг барилга бариулаад суудаггүй, тэгсэн атлаа гэрээсээ зугтаагаад явчихдаггүй. Тэгэхлээр малчин Монголчууд гэрийн тэжээмэл амтидаа энэ гайхамшигт зааг дээр барьж байдаг аргачлалыг эзэмшижээ гэж хэлж болохоор байдаг. Энэ “*зааг дээр барих ухаан*”-ыг тусгаар тогтнолоо бэхжүүлэх дипломат арга ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж болох мэт. Өөрөөр хэлбэл хоёр хөршөө Монголын тусгаар тогтнолын асуудал дээр тодорхой нэгэн заагийг давж гардаггүй рефлекстэй болгох шаардлагатай. Ийм рефлекс нэн ялангуяа Хятадын хувьд бүр ч их хэрэгтэй.

Учир нь Хятад улс их гүрнүүдийн зүгээс гардаг бусдын дотоод хэрэгт нь хутгалдан оролцдог, улс төр, эдийн засгийн хараа хяналтдаа оруулахыг оролддог зэрэг жижиг улсуудын тусгаар тогтнолыг үл тоомсорлодог үйлдлийг сайн мэддэгийн дээр Монголын тусгаар тогтнолд дэлхий дахиныг эргэлзүүлэх оролдлогыг тогтмол хугацаанд хийж хэрэгжүүлэн хятадын алдагдмал нутаг дэвсгэр гэж ойлгуулах аргачлалаа боловсронгуй болгосоор буй нь нууц биш билээ. Тайванийг авсны дараагаар (Тайвань хүчтэй учраас 50 жилийн дараа авна гэж тооцоолдог) Монголыг өөртөө нэгтгэж авахыг дэлхий нийтээс нэхэж тусгаар тогтнолы нь ганхуулна. Тэгээд хэзээ нэгэн цагт тусгаар тогтнолы нь цучлах боломж олж авна гэдэг бодлого баримталдаг нь нууц биш болсон зүйл. Тэгэхээр тодорхой заагийг Монголын асуудал дээр давж алхах боломжгүй болгох хэрэгтэй нь ойлгомжтой болж байна. Ингэхийн тулд малчин Монгол ухаанаа зарж, Монголын тусгаар тогтнолын асуудал дээр болох болохгүйн заагийг сайн мэдэрдэг хэвшлийг хоёр хөршдөө гүнзгий суулгаж өгөх хэрэгцээ бидний өмнө зайлшгүйгээр зогсож байна гэж хэлж болохоор байна. Хоёр хөрш маань ийм хэвшилтэй болох эсэх нь бидний дипломат арга ажиллагаанаас бүхэлдээ шалтгаална.

Гэрийн тэжээмэл амьтан бий болгохдоо хэрэглэсэн

аргачлалаа тусгаар тогтнолын дипломат бодлогод хэрхэн хэрэглэх вэ. *Нэгд*, хоёр хөрш маань соёлжиж боловсорч байгаа боловч их гүрнүүд учраас далд зөрчил ихтэй (тиймээс үүнийгээ зохицуулах үүднээс бүр 1989 онд зөвлөлтийн удирдагч М.С.Горбачевыг БНХАУ-д айлчлах үеэр Хөрш орнуудынхаа нутаг дэвсгэрийг бие биенийхээ эсрэг ашиглахгүй байх тухай үүрэг хүлээн авцгаасан). Ялангуяа Монголын асуудал дээр зөрчил ихтэй.² Тиймээс энэ зөрчлийг нь үл мэдрэгдэх байдлаар байнга ашиглаж Монголын асуудал дээр ямагт бие биенээсээ голоо харалтал болгоомжилж байдаг айдсын байдалд барьж байх хэрэгтэй. *Хоёрт*, дэлхий дахины эмзэг асуудлын нэг нь жижиг улсуудын тусгаар тогтнолыг хадгалах, хамгаалах, хүндэтгэх үйлс болоод байна. Энэ үйлсэд идэвхтэй оролцож, уриалан дуудаж, байнгын хувь нэмэр оруулж, энэхүү асуудлаар хоёр хөршөө гадаад талаас нь шахан бүсэлж, түүний намагт живүүлэх хэрэгтэй. *Гуравт*, хоёр хөрш маань дэлхийн бусад их гүрнүүдтэй ил далд олон зөрчилтэй³. Тэдгээрээс далд зөрчлийг нь ашиглахад ямагт бэлэн байх ёстой. Энэ далд зөрчлүүдийг илрүүлэх, судсыг нь олж барихын тулд хүчтэй судалгаа явуулж байх ёстой. *Дөрөвт*, Монгол малчин ороо догшин, эмнэг малаа байнга номхотгож байдаг шиг

² Хоёр их хөршийн хувьд Монгол орон маш эмзэг газар нь юм. Тэд 1990-ээд оны эхээр стратегийн түншлэлийн замд орохдоо Монголын асуудлыг энэ зууны эхнээс тогтсон уламжлал ёсоор нухацтай авч хэлэлцсэн байна. Хэлэлцээний явцад оросууд Монгол дахь ноёлолтоо хумиж, Хятадад өөртэйгөө энэ тэнцүү нөлөөгөө тогтоож болно гэдэг тал дээр буулт хийсэн нь үнэн. Яагаад гэвэл Монгол нь Хятадын хувьд ч гэсэн маш осолтой газарзүйн байрлалтай орон (хятадын стратегийн гол гол объектууд болох цомийн зэвсгийн бааз, цэргийн полигон, цэрэг-аж үйлдвэрийн гол гол үйлдвэрүүд манай хилийн ойролцоо, байгалийн өнгөлөн далдлалт муутай ил цагаан газарт байрлалтай байдаг. Эдгээрт агаараас болон газраас цохилт өгөхөд маш амжилттай болохоор байгаа). Гэхдээ Монгол дахь нөлөөгөө хэт их алдвал манай орон Оросын хувьд тэсрэх бөмбөг болж мэдэх талтайг оросууд сайн мэддэг.

Монголын тусгаар тогтнолыг пучлах ороо аашийг нь арилгах үүднээс улс төрийн хувьд дэлхий нийтийн анхаарлыг өөр дээрээ байлгах ажлыг байнга өрнүүлэх, эдийн засгийн хувьд хил орчмын нутагт гуравдагч орнуудын хөрөнгө оруулалтыг үлэмжхэн оруулахыг тогтмол бодлогоор (гадаадаас хөрөнгө оруулсан тохиолдолд бусдад зарах эрхийг хуулиар хааж өгөх гэх мэт) дамжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй. Тавд, малчин Монгол малаа цус ойртохоос хамгаалж байдаг шиг хоёр хөршийн урьд үеийн удирдагчдаас дараа үеийн удирдагчдад Монголын тусгаар тогтнолын асуудлаарх их гүрний шинжтэй хэсгийг улиран очих нь уу, үгүй юу гэдэгт урьдчилсан дүн шинжилгээ өгч сэргийлэх ажлыг байнга авч хэрэгжүүлж байх шаардлагатай. Зургаад, Орос-Хятадын дээд хэмжээний уулзалт дээр юу яригдаж байгаа, ямар гэрээ хэлэлцээр байгуулсан, байгуулах гэж байна, ямар тохиролцоонд хүрснийг нарийн нягт мэдэж, тэдгээрт задлан шинжилгээ хийж, алс хэтдээ чухам юу ургаж гарч болзошгүйг тааварлахыг оролдож байх ёстой.

Энэ бүхнийг улсын дотоодод хийж хэрэгжүүлэх нэн чухал ажил буюу эх оронч үзэл, тусгаар тогтнолоо юунаас ч илүү эрхэмлэх сэтгэлгээ, улс төрийн тогтвортой байдлыг баттай хангах ба эдийн засгийн хувьд хүчирхэгжих эрмэлзэлтэй бүрэн хослуулж чадвал тавьсан зорилгодоо эрхбиш хүрч болох биз ээ.

Сталины “хязгаарлагдмал тусгаар тогтнолын номлол”-д

Монгол хамаарах болсон байдаг. Анх энэхүү номлол нь европын социалист орнуудад хамааралтайгаар боловсрогдсон бөгөөд аажимдаа Хятад, Хойд Солонгос, Вьетнамд социалист хувьсгал ялснаар мөн тэдэнд ч хүртээлтэй болж, түүнтэй уялдан Монголыг хамаатуулж авсан билээ. Харин 60-аад оны эхнээс ЗСБНХУ, БНХАУ хоёрын харилцаа муудсанаас Монголын хувьд эл номлол нь “бамбай улс”-ын бодлогын уламжлалт стратегийг шингээсэн шинжтэй болж иржээ. Энэ байдал 1986 он буюу М.Горбачевийн шинэчлэлийн бодлого эхэлснээс нэг жилийн дараа ЗСБНХУ-ын ГЯЯ-ны сайд Э.Шеварднадзе бээр Зүүн Азийн орнуудад айлчилсны эцсээр төгссөн гэж хэлж болно. Монголын тусгаар тогтнолын өнгөрсөн түүхийг сөхөхөд бусдын нөлөөнд орсон улс (ялангуяа бага улс) ямар байдалтай байдгийн тэр л үлгэрээр замнаж ирсэн бөгөөд гашуун ч бай, үгүй ч бай чухам л нэрт Монголч эрдэмтэн О.Латтиморын онож бичсэнээр “...үлэмж хүчирхэг бус улс найр тавин буулт хийхээс аргагүй, бага буурай улсууд түүнээс ч үлэмж ихээр буулт хийх ёстой болдог бөгөөд тэрхүү бяцхан улс тусгаар тогтнол, хараат бус байдлаа хадгалж чадаж байна уу, аль эсвэл олон улсын эрхзүйн дагуу дархан халдашгүй болоод тэгш эрхтэй хэдий ч протекторат буюу сателлит болчихсоныг олж харахад үе үе хэцүү байдаг” гэдгийн жишээнээс гажиж чадсангүйг хэлэх юун.

Ямар ч атугай Монголын хувьд “хязгаарлагдмал тусгаар

тогтнолын номлол” нөлөөгөө алдаж, бүрэн эрхт байдлаа туйлын утгаар дөнгөж саяхнаас буюу өнгөрсөн зууны 90-ээд оноос олж авлаа. Тусгаар тогтнол бидэнд хямд унээр, тэр тусмаа амар хялбар олдоогүй гэдгийг эрхбиш ухамсарлаж, тэрхүү нүдний цөцгий мэт тусгаар тогтнолоо хамгаалан тордоход бидэнд гуравдахь хүчин зүйл зайлшгүй хэрэгтэйг мартаж аргагүй. Энэ бол цорын ганц зөв хандлага бөгөөд урьдын адил хоёр хөршийнхөө аль нэгийг дагавал тусгаар тогтнол маань нэр төдий болж хувирна.³

Горбачёвийн улс төрийн шинэ сэтгэлгээний үрээр зөвлөлт, хятадын харилцаа хэвийн урсгалд орж, ЗСБНХУ-ын ГЯЯ-ны сайд БНХАУ-д айлчлах боломж нээгдсэн юм. Э.Шеварднадзег 1986 онд Хятадад айлчлахад Монголоос цэргээ гаргавал бид аюулгүй байдлын баталгааг нь гаргаж өгнө гэж Хятадын тал мэдэгджээ. Мөн 1989 оны зун Михаил Горбачёвыг БНХАУ-д төрийн айлчлал хийх үеэр хятадын коммунист удирдлага Монголын асуудлыг улстөр-газарзүйн бодлогын (геополитикийн) үүднээс цухас хөндөөд авчээ. Түүнчлэн 1990 онд хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн ЗСБНХУ-д хариу айлчлах үеэр энэ асуудал дахин хөндөгдсөнийг эл айлчлалын үр дүн буюу Монголын нутгийг бие биеийн эсрэг түшиц газар болгож ашиглахгүй байх тухай тохиролцоо нотлон харуулж байна.

³ Сүүлийн арван жилд Монголд их гүрнүүд өөр өөрсдийн байр суурийг бэхжүүлэх оролдлого хийж ирсэн. Ялангуяа Хятад болон өрнөдийн улсууд, дээр нь Түрк улс маш идэвхтэй ажиллаж байна. Тиймээс Монголд гуравдагч орны нөлөөг дээд зэргээр саармагжуулах, бий болж бэлэжгүй хоосон орон зайг бусад улсад алдахгүй байх, ингэхийн тулд хоёр улсын зохих байгууллагууд, үүний дотор тусгай албад хамтран ажиллаж, мэдээллээ солилцож байдаг нь нууц биш билээ. Энэ бүхний огтлолшил дээр Монгол улс оршин тогтнож байна.

Б.Баяржаргал

БНХАУ-ын Фужизны Багшийн Их Сургууль,
Түүх, Нийгмийн Ухааны Сургуулийн докторант

БНХАУ-ЫН ЗҮҮН ХОЙД АЗИД ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

1. Зүүн Хойд Азид явуулж буй БНХАУ-ын бодлого

Зүүн Хойд Ази (цаашид ЗХА гэх) хэмээх шинэ нэр томъёо 1990-ээд оноос хойш гарч ирсэн ба энэ нь газарзүйн гэхээсээ улс төр, эдийн засгийн шинжтэйгээр хэрэглэгдэж байна. ЗХА-д цөмийн зэвсгээр далайлгагч БНАСАУ, байгалийн баялагийн нөөцөөрөө бүс нутгийн хөгжлийн хэрэгцээг хангах боломжтой ОХУ-ын Але Дорнод, эдийн засгийн хурдацтай өсөлт, хөгжлийн далайцаараа тэргүүлж буй орнуудын нэг болох БНХАУ-ын зүүн хойд мужууд, эдийн засаг, технологийн хүчирхэг гүрэн Япон, БНСУ, байгалийн баялгийн арвин нөөцтэй Монгол улс хамаарагддаг нь нэг талаас бүс нутаг төдийгүй дэлхийд тэргүүлэх хөгжлийн томоохон төв байх ирээдүйтэй бүс нутаг юм.

БНХАУ нь геополитик, эдийн засгийн үнэлгээгээр ЗХА-ийг хамгийн ээдрээтэй бүс нутаг хэмээн үздэг ба тус бүс нутгийн орнуудтай харилцах бодлого нь Хятадын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг байсаар ирсэн бөгөөд эдүгээ ч өөрчлөгдөөгүй байна. Тайванийн

салан тусгаарлах хөдөлгөөнтэй холбоо бүхий зөрчил / шаардлагатай үед Тайванийг эх орондоо нэгтгэх гэсэн Хятадын цэрэг-стратегийн гол зорилго буюу “Нэг Хятадын зарчим”-өөс үүдэлтэй сөргөлдөөн, Шинжаан-Уйгар, Төвөд, Өвөр Монголын салан тусгаарлах үзэлтэй холбоотой асуудлууд БНХАУ-аас бүс нутагт явуулах улс төрийн бодлогыг мөн нөхцөлдүүлдэг.

Шинэ Хятад улс байгуулагдах эхний он жилүүдэд ЗХА-аас хамгийн том сорилтууд тулгарч байв. Үүнд Дэлхийн II дайны дараах асуудлууд, Өрнө, Дорнын лагериудын сөргөлдөөн, АНУ-ын түрэмгийлэл, Зүүн Ази дахь олон улсын хамтын нийгэмлэгийн ардчилал, энх тайвны төлөөх үйл явц зэрэг нь Хятадын ЗХА дахь бодлого, үйл ажиллагааны өрнөлийн эхний үе шатыг бий болгожээ. ЗХА-ийн бүс нутгийн орнуудтай “сайн хөршийн найрсаг харилцаатай байх” бодлогыг баримтлан, аливаа маргаантай асуудлыг зөвшилцлийн замаар шийдэх, асуудлыг хурцагтахгүй хойш тавьж, аль болох нийтлэг эрх ашгийн үүднээс шийдвэр гаргаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх

нь цаашлаад дэлхийн тавцанд өөрийгөө таниулах нэгэн алхам хэмээн үзэж ирэв.

Мөн “Хойд Солонгосын цөмийн хямралыг шийдвэрлэх, энэ хойгт энх тайван тогтвортой байдлыг хадгалах нь Хятадын ЗХА-дахь бодлогын салшгүй нэг хэсэг, “Бүс ба зам” санаачлагыг хэрэгжүүлснээр бүс нутагтаа төдийгүй дэлхийн хэмжээнд тэргүүлэх гүрний байр сууринд багтай зогсож чадна гэдгээ харуулах талбар юм” хэмээн Жилиний Их сургуулийн ЗХА-ийн судалгааны хүрээлэнгийн профессор Чэн Хайтао онцолжээ.

ХКН-ын XVIII их хурлын илтгэлд хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй, бүх улс орнууд нэгэн дэлхий дээр хамтдаа оршдог, “хүн төрөлхтөний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх ойлголтыг санаачлан дэвшүүлэх хэрэгтэй гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Эндээс Ерөнхий нарийн бичиг Ши Жиньпин Хятад хийгээд хөрш орнууд хувь заяаны цогц нэгдлийг цогцлоох төлөвлөгөөг дэвшүүлсэн юм. Энэхүү үзэл баримтлал нь Хятадын гадаад бодлогын жанжин шугам “даруу байж хүчээ нөөх” биш “хүн төрөлхтний нийтлэг хувь заяаг цогцлоох”-д чиглэж, глобал

түвшинд очсоныг илтгэнэ.

“Эдийн засгийн багтаамж хийгээд бүс нутгийн нөлөөллийн хүчнээс харвал Япон, Өмнөд Солонгос, Орос нь Хятадын чухал хөрш, Хойд Солонгос болон Монгол улс Зүүн Хойд Азийн бүс нутгийн гео-стратегийн чухал ач холбогдолтой, Хятад үл ойшоож хэрхэвч үл болох хөршүүд” хэмээн Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Зүүн Өмнөд Азийн Судалгааны төвийн эрхлэгч Шюй Липин тодорхойлжээ. Тэрбээр: бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны өнцгөөс харвал ЗХА-ийн хөгжлийн цогц нэгдлийг цогцлоохын тулд Хятад улс ЗХА-ийн орнуудыг илүү олон бүс нутгийн шинжтэй нийтлэг зүйлээр хангах шаардлагатай. Бодит байдлаар харвал эцсийн хэрэглээний зах зээлийн хувьд Япон болон Өмнөд Солонгосын дотоодын зах зээл бага, Орос, Монгол нь зах зээл багаас гадна худалдан авах чадвар хязгаарлагдмал тул Хятад улс нь Япон, Өмнөд Солонгос, Монгол улс, Оросын хамгийн чухал эцсийн хэрэглээний зах зээл болж байна. Хятадын бүс нутгийн эцсийн хэрэглээний зах зээлийн чадвар нь тус улсын дотоодын хэрэгцээний цар хүрээ тэлж байгаагаас үүдэлтэй бөгөөд энэ тэлэлт нь дотоодын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт улам гүнзгийрч буйтай салшгүй холбоотой, үүнд орлогын хуваарилалт, нийгмийн халамж болон эдийн засгийн өсөлт зэрэг асуудлууд багтана. Тиймээс Хятад улс Хятад, Өмнөд Солонгосын чөлөөт худалдааны хэлэлцээрийг дотоодын өөрчлөлт шинэчлэлтийн “хөрвөж хувирах нөлөөлөл”-ийг бүрэн дайчлан гаргаж, дотоодын бодлогын зохицуулалт болон аж

үйлдвэрийн өсөлтийг түргэтгэж, дэлхийн үнэлэмжийн холбоос (Global value chain) дахь байр суурийг нэмэгдүүлж, цаашлаад өөрийн бүс нутгийн үнэлэмжийн холбоосыг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж дүгнэжээ.

2.1. Монгол Улсын талаар баримталж буй бодлого

Хятад, Монголын харилцаа, харилцан хамаарал өвөрмөц онцлогтой. Хил залгаа оршдог хөрш хоёр орны хувьд түүхэн урт хугацааны явцад бие биенээсээ болгоомжлох, улс орноо баглан хамгаалах, энх тайван, найрамдлаар зэрэгцэн орших, өөрийн эрхшээлд нөгөө орноо оруулах зэрэг бодлогыг янз бүрийн аргаар явуулж иржээ. XIII-XIV зууны үед Монголчууд дэлхийн олон орныг өөрийн эрхшээлдээ оруулсны дотор Хятадад ноёрхлоо тогтоож Юань гүрнийг байгуулж байсан. XVII-XX зууны эхэн хүртэл Монгол, Хятад хоёул Манжийн эрхшээлд орон нэг гүрний хүрээнд оршиж байгаад аль аль нь тусгаар тогтнолоо олсон. Хятадын эзэмшилд орсон олон тооны нүүдэлчин аймгууд, нүүдэлчдийн улс гүрэн дотроос ганцаараа (гэхдээ зөвхөн хэсэг нь) тусгаар тогтнолоо олон тунхаглаж өнөөг хүртэл Хятад улстай хил залган оршиж байгаа билээ.

Хятадаас монголчуудын талаар явуулах бодлогод түүний харьяанд байгаа ӨМӨЗО болон Хятадад амьдарч байгаа 6 сая монголчууд чухал байр суурь эзэлдэг. Энэхүү нөхцөл байдал нь монголчуудын хувьд явуулах Хятадын бодлогын өвөрмөц шинжийг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл монголчуудын өлгий нутаг, “Хятадын цөөнх

үндэстний газар нутаг” буюу “Хятадын газар нутаг” гэж үзэхээс эхлэн монголчуудын төрт улсуудын түүх, ялангуяа Монгол, Хятадын харилцааг хоёр улсын харилцаа гэхээсээ “Хятадын нэг гэр бүл доторх цөөнх үндэстэн хоорондын харилцаа” гэж үзэх үзэл баримтлалыг Хятадад гарч буй судалгааны ном зохиолуудад тусгасан байдаг. Чингис, Хубилай нарыг “Хятад гүрнийг нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн”, “Хятадын үндэстний цөөнхийн баатрууд”, “ Хубилай Юань гүрнийг байгуулан төр барьж байсан нь Хятадын цөөнх үндэстнээс Хятадын төрийг ээлжлэн барьж байсны илэрхийлэл” хэмээн үздэг.

1911 оны монголчуудын үндэстний эрх чөлөөний хувьсгалыг “Хаант Оросын өдөөн хатгалга, турхиралтаар үүссэн Богд Жавзандамба тэргүүтэй хэсэг цөөн эх орноосоо урвагчид, эх орноо хагалан бутаргагчдын үйл ажиллагаа гэж үздэг. “Соёлын хувьсгалын” дараа үеэс Хятадын үндэстний цөөнхийн талаарх бодлогод зарим нэг өөрчлөлт орж, монголчуудын түүх, хэл, соёлыг судлах ажил өргөн хүрээтэй хийгдэж байгаа боловч уламжлалт үзэл баримтлал үргэлжлэн тусгагдсаар байна. 1978 оноос “өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” хэрэгжүүлэх болсноор БНМАУ-тай харилцаагаа сэргээх болов. 1980 -аад оны дунд үеэс хорь гаруй жил зогсонги байсан Хятад-Монголын эдийн засгийн харилцаа сэргэж, Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаанд чухал байр суурь эзлэх болов. 1994 онд байгуулсан “Монгол улс, БНХАУ-ын найрсаг, харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ” нь улс төр, эдийн

засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны салбарт харилцаагаа хөгжүүлэх эрх зүйн үндэс болжээ.

Монгол улс Орос, Хятадаас хамаарахгүйгээр бие даасан гадаад бодлого баримтлах болж, АНУ болон барууны орнуудтай харилцаагаа хөгжүүлж буйд Хятадын тал төдийлөн сэтгэл хангалуун биш байдаг. Хятадын судлаач Ван Хайся “Хүйтэн дайны үед Хятадын геостратегид Монголын эзлэх байрлалын амин чухлыг яс махандаа хүртэл мэдэж авсан, Америкийн хүч нөлөө Монголд нэвтрэн орж буй нь түүний Хятадыг тогтоон барих стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм” гэж үзжээ. Мөн тэрбээр Монгол улс цөмийн зэвсэггүй бүс байгуулах саналыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын Хорооны 5 гишүүн орон дэмжсэн мэдэгдэл гаргасанд эмзэглэж: “Энэхүү мэдэгдэл гарснаар Монгол улс цаашдаа АНУ зэрэг өрнөдийн орнуудтай цэргийн харилцаа хөгжүүлэх төдийгүй тэднийг Хятадад довтлох цэргийн бааз, түшиц газраар ч хангаж болох юм. Иймд бид хожим амаа барихгүйн тулд хариу бодлогоо сайтар боловсруулж эрс өөрчлөлтөд бэлэн байх хэрэгтэй” гэжээ.

Өнөөгийн БНХАУ-ын төвөд, монгол зэрэг үндэсний цөөнхийн асуудал дэлхийн нийтийн анхаарлыг татсан хэвээр буй. Монгол үндэстний ихэнх нь суурьшдаг Хятад улс Монголд ардчилал хөгжсөнөөр хүний эрх, шашины эрх Хятадын цөөнх үндэстэн, түүний дотор өвөр монголчууд, төвдүүдэд нөлөөлөхөөс илт болгоомжилж ирэв.

Эдүгээ БНХАУ, Монгол улсын харилцаа “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн түвшинд хүрсэн ба харилцааны хамгийн таатай үедээ явж байна гэж судлаачид дүгнэдэг. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь хоёр орны харилцааны хамгийн чухал чиглэл юм. Улмаар “Бүс ба зам” санаачилга хийгээд түүний хүрэн дэх гурван улсын бодлогын уялдаа болох “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” нь хоёр орны хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэн нягтруулах ба худалдаа, эдийн засгийн харилцаанд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамтын ажиллагааг илүү амжилтад хүргэх боломжийг олгож байна.

2.2. Монгол - Хятадын харилцаанд тулгарч буй сорилт, бэрхшээлүүд

- Дэлхийн улс төрийн тогтворгүй байдал, ялангуяа их гүрнүүдийн геополитик, геозэдийн засгийн зөрчил, маргаан, Хятад-Америкийн худалдааны дайн, Хойд Солонгосын цөмийн хямрал, ОХУ, Ираны эдийн засгийн хориг, ЗХА-ийн орнуудын үл итгэлцэл эрсдэл дагуулж байна.

-Шийдвэр гаргах, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулах, шинэчлэх, батламжлах үйл явц хоёр талын харилцааны хөгжлөөс ихээхэн хоцрогдож байна. Хоёр талын худалдаанд чухал нөлөөтэй хил дамнасан төмөр зам барих, төмөр замын шинэ гарц нээх, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын статустай болгох,

- Монголын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний

экспорт болон гадаад өрөөс хэт хамааралтай байгаа бөгөөд Монгол банкны мэдээгээр сүүлийн жилүүдэд экспортын орлогын 88 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж, үүний 86 хувийг БНХАУ дангаар худалдан авсан байна.

-Дэд бүтцийн салбар дахь хоцрогдол, хил дамнасан ус, байгалийн болон технологийн гамшиг, агаарын бохирдол зэрэг хүчин зүйлс хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

-Соёл, хүмүүнлэгийн солилцоог эрчимжүүлж, иргэд хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, хоёр орны харилцааны нийгмийн суурийг бэхжүүлэх шаардлагатай.

-Хоёр талын судлаачдын хамтын ажиллагааг улам эрчимжүүлж, тогтолцоотой болгох, Хятад, Монголын харилцааны онолын сэтгэлгээ, стратеги төлөвлөгөө, бодлого судлалын бодит үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг асуудал болно.

Ашигласан материал

1. Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт, 2020 он, ШУА, ОУХХ
2. Хятад Улс ба хорш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй хийгээд арга зам, 2020 он, Шой Липин нарын бүтээл
3. Олон улс судлал, 2019, № (109)
4. Олон улс судлал 2018/№1 (108) он
5. Зүүн хойд азийн төлөв, байдал ба Монгол улс, 2003 он, МУИС
6. <https://mn.wikipedia.org/wiki/>
7. https://www.jstor.org/stable/resrep09679?seq=3#metadata_info_tab_contents
8. <https://www.chinathinktanks.org.cn/content/detail/id/q4bxg059>
9. <https://www.sonin.mn/news/peconomy/66391>
10. Article%20Text-3544-1-10-20190501%20(1).pdf
11. <https://miss.gov.mn/archives/587>

3.Болор

Стратеги судалгааны хүрээлэнгийн ЭША

“COVID-19” ЦАР ТАХАЛ БА ВАКЦИНЫ ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

Abstract

The pandemic continues to affect nearly every aspect of our lives, including the world economy and international affair, which shows the urgent need to collaborate both on regional and international level to address these common threats.

The strategic competition between US and China further triggered due to “Covid-19” origins study. While some countries have already turned this crisis into diplomatic opportunity for sharing their successful response measures against “Covid-19”, some are donating masks, test kit and vaccines in an effort of health diplomacy.

Subsequently, countries are competing each other for scientific research, vaccine development, and vaccine production capacity. In addition, China and Russia have been supplying vaccines through bilateral cooperation, while India donates vaccines bilaterally and multilaterally, which all of the efforts can be seen as a means of flexing their soft power muscles. Thus, this article aims to study the vaccine diplomacy on bilateral and multilateral level and pandemic impacts.

Оршил

“Covid-19” цар тахал дэлхий нийтийг хамарч олон улсын байдал, улс төр, эдийн засаг төдийгүй өдөр тутмын амьдралд нөлөөлөх болж хүний амь эрсдэж байгаа билээ. Түүнчлэн глобал шинжтэй асуудал, нийтлэг аюул, бэрхшээлийг даван туулахад улс орнууд хамтарч ажиллахын чухлыг мэдрүүлсэн бол АНУ, БНХАУ-ын хоорондын стратегийн өрсөлдөөн Covid-19 цар тахлын үүсэлтэй холбоотой маргаанаар үргэлжлэв.

Цар тахлын эсрэг авч буй арга хэмжээгээр зарим улс орнууд “үлгэрлэх” болсон бол нэн шаардлагатай амын хаалт болон оношлуур хандивлах болсноор цар тахлын үед эрүүл мэндийн дипломат ажиллагаа идэвхтэй өрнөх болсон.

Улмаар эрдэм шинжилгээ, вакцины хөгжүүлэлт, вакцин үйлдвэрлэх хүчин чадлаар улс орнууд хоорондоо өрсөлдөж, БНХАУ, ОХУ, БНЭУ бусад улс оронд вакцин нийлүүлж, вакцины дипломат ажиллагааны давалгааг эхлүүлэв. Гэтэл халдварын тоо нэмэгдэхтэй зэрэгцэн зарим улс орнууд хүн амаа вакцинжуулалтад хамруулахын хажуугаар бусад улс оронд вакцин нийлүүлэлтээ үргэлжлүүлэх хүндхэн сорилттой тулгарч буй. Нөгөөтэйгүүр, вакцин нийлүүлэлтийг нөлөөлөө бэхжүүлэх арга хэрэгсэл “зөөлөн хүчний бодлого” хэмээн харах боллоо. Иймд энэхүү өгүүллээр цар тахлын нөлөө, вакцины дипломат ажиллагааг авч үзсэн болно.

Түлхүүр үг: “Covid-19 цар тахал”, “эрүүл мэндийн дипломат ажиллагаа”, “вакцины дипломат ажиллагаа”

НЭГ. "COVID-19" ЦАР ТАХЛЫН ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр БНХАУ-ын Хубей мужийн Ухань хотод анхны тохиолдол бүртгэгдсэнээс 12 хоногийн дараа вирус судлалын хүрээлэнгээс вирус генийн бүтцийг олон нийтэд танилцуулсан билээ. Улмаар ДЭМБ (WHO) үүнээс 11 хоногийн дараа олон улсын хэмжээний онцгой байдал (PHEIC)¹, дахиад 48 хоногийн дараа цар тахал (*pandemic*) хэмээн зарласан.

Энэхүү шинэ төрлийн вирус сарьсан багваахайн вирустай 96 хувь, "SARS" коронавирусын генийн бүтэцтэй 79.5 хувь адил байгааг онцолж байв². Гэвч одоог хүртэл ДЭМБ албан ёсоор Covid-19 халдвар буюу "SARS-Cov-2" вирус эх үүсвэрийг тодорхойлоогүй бөгөөд сарьсан багваахай анхдагч эсвэл тээгч (*intermediate host*)³ байсан нь тодорхойгүй хэвээр байна. Үүний улмаас мэдээллээ нууцлалсан, "лабораториас үүссэн", өдгөө вирус мутацид орж хувирч буй гэх зэргээр БНХАУ-ыг буруутгах болсон билээ.

Ийнхүү 2021 оны эхээр "Covid-19" халдварын буюу "SARS-Cov-2" вирус эх үүслийг судлахаар ДЭМБ-ын

мэргэжилтнүүд⁴ БНХАУ-ыг зорьж, Уханий эмнэлэг, Хуанан далайн зах болон түүнээс холгүй орших Ухань вирус судлалын төвийн лабораторт тус тус зочлов⁵. Энэхүү судалгааны үр дүнг 2 дугаар сарын 9-ний өдөр хэвлэлийн бага хурлаар⁶ танилцуулж, үүнээс сарын дараа хурлын протокол ил болсон бол албан ёсны судалгааны тайлан хойшилсоор⁷ дахин сарын дараа нийтлэгдэв.

Хамтарсан судалгааны багийн зүгээс дээрх таамгийн үндэслэлийг шалгах, хэрхэн хүнд халдварласныг илрүүлэх зорилготой тул дараах тайлбарыг⁸ зарласан болно.

⁴ 2020 оны 5 дугаар сард дэлхийн эрүүл мэндийн ассемблей ДЭМБ-ыг "SARS-Cov-2" вирус эх үүслийг тодруулах хүсэлт гаргаснаар 7 дугаар сард ДЭМБ болон БНХАУ-ын хамтарсан судалгааг эхлүүлжээ. Энэхүү хамтарсан багт 10 улсын 17 толоолгогчөөс гадна БНХАУ-ын 17 шинжээчээс бүрдэх аж. Багийн бүрэлдэхүүнийг ДЭМБ-ын шинжээч Питер Бен Эмбарек ахалж, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) болон Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (OIE)-аас гадна АНУ, ИБУИНХУ, ОХУ, Япон, Дани, Нидерланд, Австрали, ХБНГУ, Катар, Вьетнамын толоолгогч нар багтжээ. WHO, "Origins of the SARS-CoV-2 virus", Jan 18, 2021 <https://www.who.int/health-topics/coronavirus/origins-of-the-virus>

⁵ ABC news, "WHO team visits Wuhan research lab at center of speculation", Feb 3, 2021, <https://abcnews.go.com/Technology/wireStory/team-visits-wuhan-research-lab-center-speculation-75650445>

⁶ "Full text: China-WHO press release of global study on COVID-19 origins", 15-Mar-2021, <https://news.cgtn.com/news/2021-03-15/Full-text-China-WHO-press-release-of-global-study-on-COVID-19-origins-YETbEy0ndu/index.html>

⁷ Reuters, "WHO says report on COVID-19 origins may be released next week", Mar 20, 2021

⁸ WHO-convened global study of ori-

Үүнд: Нэгд, Вирус лабораториас үүссэн байх бараг л боломжгүй. Хоёрт, Сарьсан багваахай эсвэл памголинаас (уламжлалт эмийн хэрэгцээнд ашиглагддаг) үүссэн байж болзошгүй бөгөөд тэр дундаа тээгч амьтнаас дамжин халдварласан. Гуравт, Хуанан далайн захад зарагддаг амьтнаас илрээгүй боловч 923 орчны шинжилгээний 73 дээжид халдвар илэрсэн гэв.

Ерөнхийдөө халдварын эх үүсвэртэй холбоотой доорх таамгийг дэлхий даяар дэвшүүлж байгаа бол ДЭМБ-ын мэргэжилтнүүд тус бүрт дараах тайлбарыг өгөв.

Таамаг 1: Амьтнаас хүнд шууд халдварласан

"SARS-Cov-2" вирус сарьсан багваахайнаас үүссэн бол энэ нь БНХАУ-ын Уханий далайн захаас гадна Мьянмар, Лаос, Вьетнам зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудад ч байдаг талаар проф. Ван Лифа онцолж⁹ байжээ. ДЭМБ-ын тайланд дурдсанаар¹⁰ Хятадын 31 мужаас 80 мянга гаруй сарьсан багваахайнд шинжилгээ хийхэд "SARS-Cov-2" вирус илрээгүй гэв.

Таамаг 2: Тээгч амьтнаар дамжин хүнд халдварласан

ДЭМБ-ын мэргэжилтнүүд жилийн дараа газар дээр нь очиж

gins of SARS-Cov-2: China Part, Joint WHO-China study team report, 14 Jan – 10 Feb, 2021

⁹ Straits Times, "Expert warns of new variants if coronavirus spreads to new wildlife hosts", Nov 12, 2020, <https://www.straitstimes.com/singapore/health/coronavirus-expert-warns-of-new-variants-if-virus-spreads-to-new-wildlife-hosts>

¹⁰ WHO-convened global study of origins of SARS-Cov-2: China Part, Joint WHO-China study team report, 14 Jan – 10 Feb, 2021

¹ WHO Covid-19 Timeline, <https://www.who.int/news-room/detail/27-04-2020-who-timeline-covid-19>

² WHO, "Report of the WHO-China Joint Mission on Coronavirus Disease 2019 (COVID-19)", Feb 16-24, 2020

³ M. Park, R. S. Thwaites, P. Openshaw, "COVID-19: Lessons from SARS and MERS", 27 Feb 2020, <https://doi.org/10.1002/eji.202070035>

Таамаг	"SARS-Cov-2" вирусн үүсэл	ДЭМБ-ын шинжээчдийн багийн тайлбар
	сарьсан багваахай - хүн?	<ul style="list-style-type: none"> сарьсан багваахай эсвэл Намголиноос гаралтай байх магадлал өндөр Ухань хотын Хуанан далайн захад дээжээс халдвар илрээгүй, түүхий махнаас илэрсэн гэх хангалттай нотолгоо алга Уханьд 2019 оны 12 сараас өмнө хүн ам дунд халдвар илэрсэн гэх нотолгоо байхгүй БНХАУ-ын Хубей мужийн болон бусад мужийн сарьсан багваахайнаас "SARS-Cov-2" вирус илрээгүй. Ухань хотод сарьсан багваахайг түгээмэл биш учир бусад газрын сарьсан багваахайг судлах хэрэгтэй.
Амьтнаас хүнд	Памголин - хүн?	
Тээгч амьтнаас хүнд	Сарьсан багваахай - харх - хүн? Ул мэдэх амьтан - Сарьсан багваахай - хүн?	<ul style="list-style-type: none"> Тээгч амьтнаар дамжиж халдсан байх магадлал маш өндөр
Хөлдөөсөн махнаас	Уханиас өмнө Италид үүсч, импортын хөлдөөсөн махнаас халдвар илэрсэн	<ul style="list-style-type: none"> "SARS-Cov-2" вирус хөлдөөсөн хүнс, савлагаагаар удаан хугацаанд дамжих магадлал бий тул үргэлжлүүлэн судлах шаардлагатай. Хуанан далайн захын хөлдөөгчөөс илрээгүй.
Лабораториас санамсаргүй тарсан	БНХАУ-ын Ухань хотын "Хуанан" далайн захаас хөнгүй орших "Уханий Вирус судлалын 4 дүгээр төвшний лабораториас үүссэн	<ul style="list-style-type: none"> Лабораториас үүссэн байх магадлал маш бага
Лабораториас зориудаар тарсан	"Уханий Вирус судлалын 4 дүгээр төвшний лабораториас санаатайгаар тараасан бол биологийн зэвсэг гэсэн үг.	

Зураг: Covid-19 халдварын гарал үүсэлтэй холбоотой таамаг ба тайлбар
Эх сурвалж: ДЭМБ-ын шинжээчдийн багийн хэвлэлийн бага хурал болон тайлангийн агуулгааас тоймлов. "Full text: China-WHO press release of global study on COVID-19 origins". Mar 15, 2021. WHO-convened global study of origins of SARS-Cov-2: China Part, Joint WHO-China study team report, 14 Jan – 10 Feb, 2021

судлаад "тээгч амьтнаар дамжин халдварласан байх магадлал өндөр" гэсэн нь сарьсан багваахайнаас өөр үл мэдэх тээгч амьтнаас хүнд халдаасан, эсвэл сарьсан багваахай өөрөө тээгч амьтан ч байж болохоор байна. Тайваний эрдэмтэн¹¹ халдвар хурдан тархсан шалтгааныг "харх"-тай холбон тайлбарлав.

Таамаг 3: Хөлдөөсөн махнаас халдварласан

"SARS", "MERS" зэрэг коронавирус хоол хүнсээр дамжсан тохиолдол байхгүй боловч амьтаны гаралтай түүхий хүнсэнд агуулагдах магадлалтай¹² гэгддэг. БНХАУ-ын тархвар судлаач Зен Гуанг "Covid-19 анх Уханьд илэрсэн боловч өөр эх үүсвэрээс үүссэн" гэсэн бол БНХАУ-ын

мэдээний агентлаг¹³ Италид 2019 оны 9 дүгээр сараас 2020 оны 3 дугаар сарын хооронд уушгины хорт хавдрын илрүүлэг шинжилгээгээр цуглуулсан пусны дээжээс "SARS-Cov-2" коронавирусын эсрэг биет илэрсэн хэмээн тодотгож, Уханиас өмнө Италид үүсэж импортын хөлдөөсөн махнаас халдварласан гэх болсон билээ.

Таамаг 4: Вирусн лабораториас санамсаргүй тарсан

Ухань хотын "Хуанан" далайн захаас 32 км зайд орших "Уханий вирус судлалын 4 дүгээр төвшний лаборатори"-ас тархсан гэх таамаг¹⁴ АНУ-ын зарим нэг сайтуудаар¹⁵ анх

¹³ 人民日报2020年11月25日, http://paper.people.com.cn/rmrbhwb/html/2020-11/25/node_866.htm

¹⁴ Washington Times Jan 26, 2020, Zero Hedge, USA Today

¹⁵ Fox news, "State Department says Wuhan lab researchers may have had COVID in the fall of 2019", Jan 15,

гарч байсан бол үүнийг БНХАУ "үндэслэлгүй гүтгэлэг"¹⁶ гэв. Улмаар АНУ-ын ерөнхийлөгч асан Трамп болон ТНБД Помпео нар "Хятадын вирус" гэхчилэн ил тодоор шүүмжлэх болсон. Учир нь 2015 онд ашиглалтад орсон тус лаборатори Ази дахь хамгийн том вирусн банк бөгөөд энд "SARS", "MERS" зэрэг 1500 гаруй төрлийн вирусн дээж байдаг гэх¹⁷.

Анх "SARS" үүсэхэд мөн Бээжингийн вирус судлалын хүрээлэнгийн 2 ажилтан халдвар авсантай¹⁸ холбож тайлбарласан боловч батлагдаагүй. Харин 2019 оны 11 дүгээр сард Уханий лабораторийн 3 ажилтан¹⁹ халдвар авсан тухай яригдах болсон билээ. Ийнхүү АНУ-ын ерөнхийлөгч Ж.Байден тагнуулын байгууллагуудад вирусн гарал үүслийг 90 хоногт судлах үүрэг өгсөн гэх.

Хэдийгээр таамаг батлагдаагүй ч Америкт явуулсан санал асуулгаар иргэдийн 29 хувь нь БНХАУ-ын лабораториас үүссэн гэж үзэж²⁰ байгаа нь Азиудыг ялгаварлах,

2021, <https://www.foxnews.com/politics/wuhan-lab-researchers-covid-china>

¹⁶ Xinhua, "Reality Check of US Allegations Against China on COVID-19", 2020-5-10.

¹⁷ The Straits Times, "The Wuhan lab at the core of a coronavirus controversy", Apr 17, 2020

¹⁸ 光明观察, "香港媒体: 谁该对这次SARS病毒泄漏负责", 2004-06-15, <https://guancha.gmw.cn/2004-6/15/1746001.htm>

¹⁹ Business Insider, "3 Wuhan lab worker were sick enough to be hospitalized in Nov 2019, triggering calls to reconsider theory that Covid-19 originated in a lab: WSJ", May 2021

²⁰ Pew Research Center, "Nearly three-in-ten Americans believe COVID-19 was made in a lab", Apr 3, 2020, <https://www.pewresearch.org/fact-tank/2020/04/08/nearly-three-in-ten-americans-believe-covid-19-was-made-in-a-lab/>

үзэн ядах үзэл газар авах болсныг илтгэж байна.

Түүнчлэн ДЭМБ-ын шинжээчдэд шахалт үзүүлж байгаа хэмээн хардаж²¹, судалгаагаар ил тод, нээлттэй²² хийхийг олон улсын судлаачид уриалсаар байгаа билээ. Гэвч үр дүн ямар байхаас үл шалтгаалан олон улсад улс төржиж, мэдээллээ нууцалсан гэх зэргээр БНХАУ-ыг буруутгаж байгаа нь АНУ, БНХАУ-ын хооронд сөргөлдөх нөхцлийг бүрдүүлж байна.

ХОЁР. “COVID-19” ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, НӨЛӨӨ

“Covid-19”-ийн эсрэг БНХАУ-ын авч хэрэгжүүлсэн хатуу арга хэмжээг шүүмжилж байсан улс орнууд хожим нь хөл хорио тогтоож, олон нийтийн цугларалтыг багасгахаас өөр аргагүйд хүрсэн юм.

БНСУ аль болох олон хүнийг шинжилгээнд хамруулах бодлого баримталж, “машинтайгаа” болон “утасны бүхээг”-т оношлуулах зэрэг дэвшилтэт, хялбаршуулсан аргаар ялгарах болж, “хүний эрх зөрчихгүйгээр” цар тахалтай тэмцсэн туршлага, хариу арга хэмжээний загвараа олон улсад сурталчилж, улс орныхоо нэр хүндийг өсгөх боллоо. Хямралыг боломж болгон ашиглаж буй хүчин чармайлтын дүнд Мүн Жэ Ин

ерөнхийлөгчийн²³ болон намын нэр хүнд өсч 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр парламентын сонгуулиар ялалт²⁴ байгуулав. Үүнд “MERS”, “SARS” зэрэг өмнөх туршлагын улмаас эрүүл мэндийн хангамж сайн, тахалд бэлтгэлтэй байсан нь ихээхэн нөлөөлсөн. *Нөгөөтэйгүүр, “Covid-19”-ийн эсрэг авч буй арга хэмжээ нь бусад дуулиан, гадаад бодлогын алдааг “түр хугацаанд” умартуулж байна. Тухайлбал, БНСУ-д “Covid-19”-ийн халдвар идэвхжих үед сая гаруй хүн ерөнхийлөгч Мүн Жэ Инийг огируулахын төлөө гарын үсэг зурж, дэлхийн улс орнууд БНСУ-ын эсрэг хилийн болон хөл хорио тогтоох үед БНСУ-ын гадаад харилцааны сайдыг буруутгаж байсан билээ.*

Япон улс цар тахлын улмаас 2020 оны Токиогийн олимп, параолимпийг 2021 оны зун хүртэл жилээр хойшлуулахаас²⁵ өөр аргагүйд хүрсэн. 1940 онд Япон зуны ба өвлийн олимпийн эрхийг авсан байсан ч дэлхийн хоёрдугаар дайны улмаас хойшлуулсан түүхтэй. Ингээд 40 жилийн дараа дахиад хойшлуулснаар Япон 2.3 тэрбум ам.долларын алдагдалд²⁶ оржээ. 2021 оны 7 дугаар сарын 23-наас

²³ БНСУ-ын Солонгосын хойг дахь энх тайвны бодлого зогсонги байдалд орсоноор ерөнхийлөгч Мүн Жэ Иний рейтинг 39 хувь хүртэл унаж байсан бол Covid-19 цар тахлын эсрэг дипломат ажиллагаагаар түүний рейтинг өсч 53.9 хувьд хүрсэн.

²⁴ CNN, “South Korea sees the largest turnout in almost 30 years in election held during coronavirus outbreak”, Apr 16, 2020

²⁵ “Joint statement from the International Olympic Committee and the Tokyo 2020 organizing committee”, Mar 24, 2020

²⁶ Asahi, “40-year cycle: Japan minister calls 2020 the ‘cursed Olympics’”, Mar 19, 2020

8 дугаар сарын 8-ны хооронд Токиогийн олимпыг халдвар хамгааллын дүрмийг чанд сахиж²⁷ зохион байгуулахаар болсон боловч зарим хотод онц байдал үргэлжилсээр байгаа болон санал асуулгаар иргэдийн 70 хувь олимпыг цуцлах, эсвэл дахин хойшлуулах хүсэлтэй байна²⁸.

ГУРАВ. ВАКЦИНЫ ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА

Улс орнууд хүмүүнлэгийн тусламжаар “амны хаалт”, “оношлуур” болон эмнэлгийн тоног төхөөрөмж, вакцин хандивлах зэргээр түншлэл, хамтын ажиллагаагаа бататгаж байгаа нь эрүүл мэндийн дипломат ажиллагаа идэвхтэй өрнөж буйг илтгэж байна.

1. Олон талт хамтын ажиллагааны хүрээнд

ДЭМБ болон бусад байгууллагын хүрээнд “Covid-19” эсрэг вакцин, оношлуур, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бүх улс оронд тэгш хуваарилах механизм буюу “COVAX” хотөлбөрийг 2020 оны 4 дүгээр сард байгуулжээ²⁹.

Энэ хүрээнд 2021 оны эцэс гэхэд 2 тэрбум тун вакциныг бага, дунд орлоготой улс оронд хүртээмжтэй тараах бөгөөд өдгөө 190 улс нэгдэн орсон байна³⁰.

²⁷ Nikkei, “Still in play: Japan’s Olympic dream burns on”, Nov 19, 2020

²⁸ BBC, “Tokyo Olympics: Why doesn’t Japan cancel the Games?”, May 15, 2021

²⁹ WHO, “COVAX”, <https://www.who.int/initiatives/act-accelerator/covax>

³⁰ UNICEF, “COVAX: ensuring global equitable access to COVID-19 vaccines”, <http://www.unicef.org/supply/>

²¹ Z.Evans, “WHO Gave China Veto Power over American Scientists Joining COVID-Origin Investigation”, The National Review, Mar 18, 2021

²² CBS, “Geopolitical expert calls for transparency from China on COVID-19 origins”, Mar 17, 2021

Ийнхүү 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр анхны вакциныг хүлээлгэн өгснөөс хойш өдгөө 81.7 сая тун³¹ вакциныг 129 оронд хандивлажээ.

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд энэхүү хөтөлбөр нь дэлхийн түүхэнд хамгийн том вакцинжуулалт болж байгаа бөгөөд вакцинжуулалтын талаарх мэдээллийг төвлөрүүлэх, хүртээмжтэй байлгах аас гадна түгээлтийн болон хаягдлын аюулгүй байдлыг хангах давхар ач холбогдолтой билээ.

Аливаа вирусын эсрэг вакцин гаргаж авахад 10-15 жил³² зарцуулдаг гэгддэг бол цар тахлын хэмжээнд хүрч дэлхий дахинд хөл хорио тогтоосон зэргээс шалтгаалан вакцин гаргаж авах үйл явцыг хурдасгах зорилгоор ДЭМБ болон бусад холбогдох байгууллагууд вакцинд яаралтай горимоор зөвшөөрөл олгож байна.

2021 оны 6 дугаар сарын 8-ны байдлаар “SARS-Cov-2” вирусын эсрэг нийт 287 вакцины туршилт байгаагаас эмнэлзүйн (клиник) туршилтын шатанд 102 вакцины туршилтын үр дүн бүртгэгджээ³³.

Хүснэгт: Вакцинд яаралтай горимоор зөвшөөрөл олгосон байдал

	ДЭМБ-ын шаардлагыг бүрэн хангасан хэмээн эцсийн дүгнэлт гарсан ³⁴	ДЭМБ-ын Яаралтай горимоор хэрэглэх зөвшөөрөл (EUI) олгосон	АНУ-ын Хүнс, эмийн чанарын хяналтын газар (FDA) яаралтай горимоор зөвшөөрсөн (EUA) ³⁵	ЕХ-ны Эмийн хяналтын байгууллага (EMA) зөвшөөрсөн ³⁶
Pfizer	*	*	*	*
AstraZeneca	*	*		*
Moderna	*	*	*	*
Janssen	*	*	*	*
Sinopharm (BIBP)	*	*		
SinoVac	*	*		үнэлгээ хийж буй
Novavax		*		үнэлгээ хийж буй
CanSinoBio		*		
CureVac				үнэлгээ хийж буй
Sputnik V				үнэлгээ хийж буй

(2021 оны 6 дугаар сарын 13-ны байдлаар тоймлов.)

Үүнээс харахад БНХАУ-ын “Sinopharm (BIBP)” болон “SinoVac” вакцин ДЭМБ-ын шаардлагыг хангасан бол ОХУ-ын “Sputnik V” вакцин ДЭМБ болон ЕХ-ны зүгээс үнэлгээ хийх шатандаа явж байна.

■ Энэтхэг, Номхон далайн Вакцины мэргэжилтний групп (Quad)

АНУ, Япон, БНЭУ, Австрали дөрвөлийн хүрээнд 2021 оны 3 дугаар сарын 12-нд “Вакцины мэргэжилтний групп” (Quad Vaccine Experts Group)-ыг байгуулсан бөгөөд энэ хүрээнд Энэтхэг-номхон далайн бүс нутагт 2022 оны эцэс гэхэд 1 тэрбум тун вакцин нийлүүлэхээр болов³⁷. Мөн ДЭМБ-д “ил тод, үр дүнд суурилсан шинэчлэлт” хийхэд талууд хамтрахаар болсон бол цаашид шинжлэх ухаан, баримтад тулгуурласан эрүүл мэндийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжих аж. Энэ хүрээнд БНЭУ-д

covax-ensuring-global-equitable-access-covid-19-vaccines

³¹ UNICEF, “COVID-19 Vaccine Market Dashboard”, as of June 10, 2021, <https://www.unicef.org/supply/covid-19-vaccine-market-dashboard>

³² “Vaccine Development, Testing, and Regulation”, <https://www.historyofvaccines.org/content/articles/vaccine-development-testing-and-regulation>

³³ WHO, “Landscape of Candidate vaccine in a clinical development”, Jun 8, 2021 <https://www.who.int/publications/m/item/draft-landscape-of-covid-19-candidate-vaccines>

³⁴ WHO, “Status of COVID-19 Vaccines within WHO EUL/PQ evaluation process”, Jun 3, 2021

³⁵ US Food and Drug Administration, “COVID-19 Vaccines”,

³⁶ EMA, “COVID-19 vaccines: authorized”, <https://www.ema.europa.eu/en/human-regulatory/overview/public-health-threats/coronavirus-disease-covid-19/treatments-vaccines/vaccines-covid-19/covid-19-vaccines-authorized>

³⁷ Fact Sheet: Quad Summit The Quad Vaccine Partnership, Mar 12, 2021, <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/03/12/fact-sheet-quad-summit/>

буй үйлдвэрлэлийг түшиглэн үр дүнтэй, аюулгүй вакцин нийлүүлэх бол Японы зүгээс хөгжиж буй орнуудад вакцин худалдаж авахад зориулан зээл тусламжаар дэмжлэг үзүүлэхээр болж, Австралийн хувьд ЗӨА-д вакцин түгээхэд зориулан 77 сая ам.долларын тусламж үзүүлж байна. Харин АНУ-ын зүгээс бүс нутгийн вакцинжуулалтад 100 сая ам.доллар хандивлахаа тухайн үед зарлаж байв.

6 дугаар сарын 10-ны өдөр “COVAX” хөтөлбөрөөр 500 сая “Pfizer”³⁸ вакцин жилийн дотор 92 бага дунд орлоготой улс орнуудад хандивлана гэжээ.

■ БНЭУ-ын вакцины дипломат ажиллагаа

Дэлхийн вакцины 60 орчим хувийг үйлдвэрлэгч БНЭУ-ын зүгээс ИБУИНХУ-ын “AstraZeneca – Oxford” вакциныг үйлдвэрлэх гэрээнд 2020 оны 4 дүгээр сард гарын үсэг зурав. Энэ хүрээнд БНЭУ-ын “Серүм” хүрээлэн 1 тэрбум тун “Covishield” (AstraZeneca) вакциныг үйлдвэрийн өртгөөр 50 хувийг дотооддоо, үлдсэнийг бага дунд, орлоготой улс орнуудад нийлүүлэхээр болжээ³⁹. Ийнхүү БНЭУ “COVAX” хөтөлбөрийн хүрээнд олон талт болон хоёр талын шугамаар вакцин идэвхтэй нийлүүлсээр ирэв. Тодруулбал, 2021 оны 2 дугаар сараас эхлэн “Хөрш нэн

³⁸ White House briefing, “FACT SHEET: President Biden, Announces Historic Vaccine Donation: Half a Billion Pfizer Vaccines to the World’s Lowest-Income Nations”, Jun 10, 2021

³⁹ Shiming Yang, “Rising-Power Competition: The Covid-19 Vaccine Diplomacy of China and India”, Mar 21, 2021, National Bureau of Asian Research Emerging Voices on the New Normal in Asia

тэргүүнд” бодлогынхоо хүрээнд хоёр талын шугамаар Өмнөд Ази, ЗӨА, Африкт нийлүүлээд эхэлсэн бөгөөд өдгөө 150 сая тун вакциныг хандивлажээ.

Гэвч дотоодын халдвар огцом нэмэгдэж, вакцинжуулалт удаан байгааг шүүмжлэх болж улмаар “Covishield” вакциныг тодорхойгүй хугацаагаар экспортлохоо хойшлуулав⁴⁰. Энэ нь Энэтхэг-номхон далайн дөрвөлийн хүрээнд вакцин нийлүүлэхэд нөлөөлсөн болов уу.

■ БНХАУ-ын вакцины дипломат ажиллагаа

Вакцин хөгжүүлэлтийг төрөөс дэмжиж, төр, хувийн хэвшлийг нэгтгэсэн судалгааны баг бүхий 24 вакцин туршилтаа бүртгүүлсэн байна. “Sinopharm (BIBP)”, “Sinopharm (Wuhan)”, “Sinovac”, “CanSinBio”, “Anhui Zhifei Longcom” “Minghai biotech” 6 вакцин дотооддоо зөвшөөрөл авсан бол үүнээс “Sinopharm (BIBP)”, “Sinovac” вакцин ДЭМБ-ын эцсийн дүгнэлт болон яаралтай горимоор зөвшөөрөл авчээ. Ингэснээр Хятадын вакцин “COVAX” хөтөлбөрөөр олон улсад түгэх боломж нээгджээ. Вакцин үйлдвэрлэгч тус бүр жилдээ 300 орчим сая тун вакцин үйлдвэрлэх хүчин чадалтай аж⁴¹.

“Sinopharm (BIBP)” вакциныг хамгийн их буюу 47 улсад, “Sinovac” вакциныг 26 улсад⁴² бүртгэсэн бөгөөд 80 гаруй улс оронд вакцин

⁴⁰ BBC, “Coronavirus: India temporarily halts Oxford-AstraZeneca vaccine exports”, Mar 25, 2021

⁴¹ Shiming Yang, “Rising-Power Competition: The Covid-19 Vaccine Diplomacy of China and India”, Mar 21, 2021, National Bureau of Asian Research Emerging Voices on the New Normal in Asia

⁴² Covid-19 vaccine tracker

экспортолжээ. Эдгээр улсын дийлэнх нь⁴³ БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилгад (Belt and Road Initiative) оролцогч орнууд аж. Эл санаачилгын хүрээнд “Эрүүл мэндийн Торгоны зам” хамтын ажиллагааны механизмыг 2015 онд зарлаж байсан бол улмаар хөгжиж буй орнуудад амны хаалт, эрүүл мэндийн тусламж илгээх⁴⁴ болсон юм. Үүнийг судлаачид амны хаалт, вакцины дипломат ажиллагаагаар БНХАУ олон улсад геополитикийн нөлөөллөө бэхжүүлж, улс төрийн нөхцөлтэйгээр вакцин хандивлаж байна хэмээн үзэх болов⁴⁵. Үүний хариуд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И “Өрнөдийн орнууд өөрсдийн хүн амыг вакцинжуулж байхад бид аль болох түргэн шуурхай олон хүнийг вакцинжуулахыг хүссэн”⁴⁶ хэмээн тайлбарлав. Түүнчлэн “хүний эрх ярьдаг, хангалттай вакцинтай атлаа АНУ амиа бодож”⁴⁷ буй явдал БНХАУ-ын вакцинд эргэлзэхэд нөлөөлж⁴⁸ байна гэв.

2. Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд

Хэдийгээр БНЭУ-ын вакцины дотоод туршилт үргэлжилж байгаа боловч олон улсад нийлүүлж буй гол вакцин

⁴³ Alexander Smith, “Russia and China are beating the US at vaccine diplomacy, experts say”, NBC, Apr 2, 2021

⁴⁴ Think Global Health, “The politics of vaccine donation and Diplomacy”, Apr 8, 2021

⁴⁵ “Coercion or altruism: Is China using its Covid vaccine to wield global power?”, The Guardian, Mar 27, 2021

⁴⁶ 外交部, “王毅: 为保护全人类生命健康作出更多“中俄贡献”, 2021-03-23

⁴⁷ 人民网, “国际观察: “疫苗外交论”暴露美国阴险与冷血”, 2021-03-22

⁴⁸ 新华社, 新华时评: 指责中国“疫苗外交”, 居心险恶, 2020-12-24

нь “AstraZeneca буюу “Covishield” юм. Харин ОХУ-ын хувьд дотоодод үйлдвэрлэсэн вакцинаар хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд бусад улс оронд вакцин нийлүүлж байна.

■ ОХУ-ын вакцины дипломат ажиллагаа

“Sputnik V” вакцинд ДЭМБ-ын зүгээс яаралтай горимоор зөвшөөрөл олгоогүй боловч үр дүн нь 90 хувиас дээш үзүүлэлттэй, түгээлтийн нөхцөл амар, зах зээлийн үнээс хямд бөгөөд өдгөө 65 оронд бүртгэгдэж, 2 сая орчим хүн хамрагджээ⁴⁹. Үүнээс гадна нэг тун “Sputnik light” вакциныг танилцуулаад амжсан билээ.

ЕХ-ны Эмийн хяналтын байгууллага (EMA) “Sputnik V” вакциныг зөвшөөрөөгүй ч Унгар, Словакт⁵⁰ вакцинжуулаад эхэлсэн тул хамтын нийгэмлэгийн бодлого “нэгдмэл” байж чадаж байгаа эсэх, улс орнуудын дунд ОХУ-ын талаарх байр суурийн ялгаатай байдал цаашид хэрхэх нь тодорхойгүй байна.

ЗХУ анх 1957 онд “Спутник” хиймэл дагуулыг хөөргөсөнтэй адил шинжлэх ухаан, технологийн чадавхиар дэлхийг дахин гайхшруулж байгаа бол уг вакцин ОХУ-ын хамгийн амжилттай зөөлөн хүчний бодлого⁵¹ болох бололтой. Энэ тухай вакцины албан ёсны цахим хаягтаа вакциныг дэлхийд зарласнаар “Спутник агшин”-ыг бий болгосон гэв.

БНХАУ-д “Sputnik V” болон ОХУ-д “CanSinoBio” вакциныг харилцан үйлдвэрлэж байгаа бол Төв Азид БНХАУ, ОХУ хоёр вакцин нийлүүлэлтээр өрсөлдөх хандлага ажиглагдаж⁵² байна.

ДУГНЭЛТ

Вакцины дипломат ажиллагаа олон улсын түвшинд “COVAX” хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бол ОХУ хоёр талын шугамаар улс орнуудад вакцин нийлүүлж буй. Харин БНХАУ- БНЭУ хоёр аль аль шугамаар “хөгжиж буй орнуудад” түлхүү хандивлаж байна. Гэвч халдварын тоо хаяагүй нэмэгдэхтэй зэрэгцэн эдгээр улсууд хүн амаа вакцинжуулахын зэрэгцээ бусад улс оронд нийлүүлэх хүндхэн сорилттой тулгарч буй. Нөгөөтэйгүүр, АНУ, ЕХ, ИБУИНХУ зэрэг уламжлалт хандивлагч нар дотоодын вакцинжуулалтад анхаарч байгаа нь БНХАУ-д хоосон орон зай бий болгосон. Хятад вакцин ДЭМБ-д хүлээн зөвшөөрөгдөөд зогсохгүй хамгийн олон улсад бүртгэгдэж вакцины том үйлдвэрлэгч болсон нь зарим улс оронд цорын ганц сонголт болжээ. Халдварын болон вакцинжуулалтын нөхцөл байдал өдөр бүр шинэчлэгдэж байгаа тул цаашид хэрхэн өрнөх нь тодорхойгүй байна.

- Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах нь зөвхөн нэг улсын бус, нийтлэг асуудал бөгөөд цар тахал, халдварт өвчин зэрэг нь олон улсад ямар их аюул учруулж болох нь тодорхой харагдав. Иймд цаашид бүс нутгийн болон олон улсын түвшинд эрүүл мэндийн хамтын ажиллагааг сайжруулахад анхаарч, олон санал, санаачилга гарах болов уу.
- Трампын үед дэвшүүлсэн “Энэтхэг-Номхон далайн стратеги” болон ДЭМБ-тай холбоотой “Covid-19” халдварын гарал үүслийн маргааныг ерөнхийлөгч Ж. Байдены засаг захиргаа үргэлжлүүлэх хандлагатай байна.
- “SARS-CoV-2” вирусыг гүнзгийрүүлэн судлах нь халдварын эх үүсвэрийг тодорхойлох, ойлгох, тэмцэхэд дөхөмтэйгээс гадна цаашид зэрлэг амьтнаас хүнд халдварлах боломжит вирусыг судалж дараагийн хувилбар “SARS-CoV-3” гарах нөхцөлд бэлтгэлтэй байх шаардлагатай. Энэ хүрээнд улсын эрүүл мэндийн чадавхийг сайжруулах, шинжлэх ухаанч судалгаанд хөрөнгө оруулах, цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсронгуй болгоход анхаарах хэрэгтэй байна.

⁴⁹ Sputnik V vaccine. <https://sputnikvaccine.com/about-vaccine/>

⁵⁰ Euro news, “Slovakia is second EU country to roll out Russia’s Sputnik V COVID-19 vaccine”, Jun 7, 2021

⁵¹ BBC, “Sputnik V: How Russia’s Covid vaccine is dividing Europe”, Apr 17, 2021

⁵² Elizabeth Wishnick, “China and Russia: Vaccine Competitors or Partners?”, The Diplomat, Feb 21, 2021

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- WHO, “Landscape of Candidate vaccine in a clinical development”
- WHO, “Status of COVID-19 Vaccines within WHO EUL/PQ evaluation process”
- WHO, “Report of the WHO-China Joint Mission on Coronavirus Disease 2019 (COVID-19)”, Feb 16-24, 2020
- “Full text: China-WHO press release of global study on COVID-19 origins”, 15-Mar-2021,
- WHO, “Origins of the SARS-CoV-2 virus”, Jan 18, 2021 <https://www.who.int/health-topics/coronavirus/origins-of-the-virus>
- EMA, “COVID-19 vaccines: authorized”, <https://www.ema.europa.eu/en/human-regulatory/overview/public-health-threats/coronavirus-disease-covid-19/treatments-vaccines/vaccines-covid-19/covid-19-vaccines-authorized>
- Fact Sheet: Quad Summit The Quad Vaccine Partnership, Mar 12, 2021, <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/03/12/fact-sheet-quad-summit/>
- WHO, “COVAX”, <https://www.who.int/initiatives/act-accelerator/covax>
- UNICEF, “COVAX: ensuring global equitable access to COVID-19 vaccines”, <http://www.unicef.org/supply/covax-ensuring-global-equitable-access-covid-19-vaccines>
- UNICEF, “COVID-19 Vaccine Market Dashboard”, as of June 10, 2021, <https://www.unicef.org/supply/covid-19-vaccine-market-dashboard>
- “Vaccine Development, Testing, and Regulation”, <https://www.historyofvaccines.org/content/articles/vaccine-development-testing-and-regulation>
- Shiming Yang, “Rising-Power Competition: The Covid-19 Vaccine Diplomacy of China and India”, Mar 21, 2021, National Bureau of Asian Research Emerging Voices on the New Normal in Asia
- Think Global Health, “The politics of Vaccine donation and Diplomacy”, Apr 8, 2021
- Ariel Bogle, Albert Zhang, “China and India tussle online over vaccine diplomacy”, Feb 9, 2021, Australian Strategic Policy Institute
- Alexander Smith, “Russia and China are beating the US at vaccine diplomacy, experts say”, NBC, Apr 2, 2021
- “Coercion or altruism: Is China using its Covid vaccine to wield global power?”, The Guardian, Mar 27, 2021
- Olga Krasnyak, “From vaccine nationalism to vaccine diplomacy”, Policy forum,
- Rosie Wigmore, “5 Reasons to Worry About the ‘Chinese Vaccine Diplomacy’ Narrative”, The Diplomat, Mar 11, 2021
- 外交部, “王毅: 为保护全人类生命健康作出更多“中俄贡献”, 2021-03-23
- 新华社, “新华时评: 指责中国“疫苗外交”, 居心险恶, 2020-12-24
- 人民网, “国际观察: “疫苗外交论”暴露美国阴暗与冷血”, 2021-03-22



Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа
Нийтийн Удирдлагын Сургууль

МОНГОЛ УЛСАД ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ДИПЛОМАТ АЛБАНЫ
ЧИГЛЭЛЭЭР ҮНДЭСНИЙ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛДЭЖ ЭХЭЛСЭН
ТҮҮХТ 30 ЖИЛИЙН ОЙН **БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!**

ТООН МЭДЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн найм дахь удаагийн сонгуулийн санал хураалт 6 дугаар сарын 9-ний 07.00-22.00 цагийн хооронд болж өндөрлөв. Сонгуульд 2087 хэсгийн хороонд нийтдээ 2.041.866 сонгогч санал өгөхөөр нэрийн жагсаалтад бүртгэгдсэн. Бүртгэгдсэн сонгогчдын олонх буюу 59,35 хувь нь оролцлоо. /Үүнээс 71.680 сонгогч цагаан сонголт хийжээ/.

Нийт 1.206.858 сонгогч саналаа өгснөөс:

- МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүх-823.326 санал
- АН-аас нэр дэвшигч С.Эрдэнэ 78.832 санал
- Зөв хүн электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбат 246.968 санал авсан байна.

Нийт 22300 төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч, мэдээллийн технологийн 2800 албан хаагч ажилласнаас гадна, онцгой байдлын болон эрүүл

мэндийн байгууллагын нийт 5474 албан хаагч, 3137 иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 8500 албан хаагч нийт 42211 төрийн албан хаагч ажиллалаа.

Дотоодын 80 хэвлэл мэдээллийн 450 гаруй сэтгүүлч, зураглаач, инженер техникийн ажилтнууд ажилласанаас гадна гадаадын хэвлэл мэдээллийн 13 байгууллагын 16 сэтгүүлч, сурвалжлагчид ажиллажээ.

ХУАНЛИ

1991-2021- МУИС-ийн ОУХНУС-ийн 30 жилийн ой

1 сар

- 30 жилийн ойн лого бүтээх уралдаан

2 сар

- Төгсөгчдийн Форум

3 сар

- “Эх орныхоо хөгжилд оруулах миний хувь нэмэр” эссэ бичлэгийн уралдаан

4 сар

- Монголын МГИМО төгсөгчдийн холбооны төлөөлөлтэй хийх үулзалт

5 сар

- Кубын Дипломатын Академи, Санамж бичиг байгуулах ёслолын ажиллагаа
- “Үндэсний даван туулах чадвар: Монголын Резилиенс” Академик хэлэлцүүлэг
- “SIRPA Төгөл” Мод тарих үйл ажиллагаа

6 сар

- “Монгол-Оросын дипломат харилцааны 100 жил” сэдэвт ОУЭШХ

- Дипломат ёслолын киноны Оскар шагнал гардуулах ёслолын ажиллагаа

7 сар

- Тайваны Үндэсний Чинан их сургуультай хамтарсан ОУЭШХ (7/3)
- Канадын Дипломат Академитай хийх үулзалт

9 сар

- “Русский Дом” нээлт, Номын хандивын үйл ажиллагаа

10 сар

- ОББЭЭС төгсөгчдөд Хүндэтгэл үзүүлэх үулзалт
- Монгол улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин” номын нээлт, хэлэлцүүлэг
- “Мини НҮБ” загвар хуралдаан
- “Сансрын аюулгүй байдал, орон зайн геополитик” МОСААХ-тай хамтарсан аюулгүй байдлын академик хэлэлцүүлэг

- МГИМО-ийн Ректор Торкуновтой хийх үулзалт

11 сар

- “Монгол-Польшийн дипломат харилцаа: Өнгөрсөн, одоо, ирээдүй” ОУЭШХ
- Варшавын их сургуулийн Олон улс судлалын сургууль, Санамж бичиг байгуулах ёслолын ажиллагаа
- SIRPA STUDENT Conference – 2021 бакалавр, магистр, докторын оюутны ЭШХ
- Мини парламент хуралдаан

12 сар

- “SIRPA FORUM 2021: Олон улсын харилцаан дахь шинэ чиг хандлага ба Монгол улс” (12/4-5)
- VIP Хүндэтгэлийн лекц
- “Монголын Геополитик” академик мэтгэлцээн –V
- “Хүндэт доктор” цол гардуулах ёслол хүндэтгэлийн ажиллагаа
- Фото зургийн үзэсгэлэн
- 30 жилийн ойд зориулсан Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу-1, МУИС-ийн хичээлийн V байр, 201 тоот өрөө

sirparo@num.edu.mn, sukheebattulga@num.edu.mn
7730-7730-5101
976-9901-9977